# Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын эрх, үүрэг

**О.Одбаяр**
**ХБХ-ийн дарга**



Аймаг, Нийслэл, хотын ерөнхий архитектор нь дараах хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан дүрэм, журам, заавар, шийдвэр, норматив баримт бичгүүдийг мөрдлөг болгоно.



# ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

## Аймаг, Нийслэлийн Ерөнхий архитекторын эрх, үүрэг /10 дугаар зүйл/



Хот байгуулалтын салбарын эрх зүйн актыг боловсруулах, өөрчлөх тухай санал оруулах



Орон нутгийн хот байгуулалтын үйл ажиллагааг зохицуулж хот байгуулалт барилга захиалагчийн албыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах



Орон нутаг дахь хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах



Газрын ХЕТ-ний гудамжны нэр, барилгын дугаарыг тогтоож газрын кадастрын бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулах



Зураг төсөл хайгуул, шинжилгээний ажлыг орон нутагт зохион байгуулах



Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг ИТХ батлуулж хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх



Хот байгуулалтын кадастр, архивын сан үүсгэх



Инженерийн бэлтгэл ажилд хяналт тавих

# БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ










Барилга барих хүсэлтийг мэргэжлийн комисийн хурлаар хэйлэлцүүлж зөвшөөрөгдсөн тохиолдолд Архитектур төлөвлөлтийн даалгаварыг барилгын гүйцэтгэгчид хүргүүлэнэ

Батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу барилгын ажлын эхлүүлэх, үргэлжилүүлэх зөвшөөрлийг олгоно.

Барилга баригдаж дуусхад барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс ажиллуулж ашиглалтанд хүлээлгэн өгөх

Барилгын хөрөнгө оруулагч нь барилга байгууламж барих газрын зөвшөөрөл авах техникийн нөхцөл бүрдүүлэх, зураг төсөл захиалах үүрэгтэй

# Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хууль

**1**



Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний дагуу нарийвчилсан төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

**2**



Хот тосгоны нутагт барилга байгууламж барих зөвшөөрөл олгох талаар санал гарган, ашиглалтанд орж байгаа орон сууц иргэний зориулалттай барилга байгууламжийг хүлээн авах

**3**



Хот тосгоны экологи, эрүүл ахуйн хэм хэмжээ зөрчсөн барилга байгууламжийг барьж ашиглахыг зогсоох

**4**



Хот тосгоны экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах, сэргээх арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

# Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль

**1**



Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах

**2**



Ашиглалтын шаардлага хангахгүй барилга, байгууламжийг буулган шинээр барих

**3**



Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах

**4**



Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах

**5**



Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах

## ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Аймаг, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барьж батлуулах.



## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

Шинээр барих, өргөтгөх барилга байгууламжийг ус хангамжийн болон ариутгах татуургын шугам сүлжээнд холбоход тавигдах шаардлага нөхцөлийг тусгасан зөвшөөрлийг олгоно.

Ус хангамжийн бүсийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж бариулахгүй байх үүрэгтэй.



## ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬ

Аймаг, Нийслэлийн засаг дарга, ИТХ-ын бүрэн эрх, үүргийн хүрээнд дараах чиг үүргийг Ерөнхий архитектор хэрэгжүүлнэ.




Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин төлөвлөх



Нутаг дэвсгэртээ орон сууц хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж ИТХ –д өргөн барьж мэдүүлэх.

## УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ

Аймаг, Нийслэлийн ИТХ-ийн бүрэн эрх, үүргийн хүрээнд дараах чиг үүргийг Ерөнхий архитектор хэрэгжүүлнэ.

Ус, усны орчинг ашиглах, хамгаалах нөхөн сэргээх, усны барилга байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг удирдах.



- “Хот, тосгоны барилгажилт, төлөвлөлтийн норм ба дүрэм”
  БНбД 30-01-04
- “Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм”
  БНбД 11-01-98
- “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрэм”
  ЗТБХБ-ын Сайдын 2011 оны 226 дугаар тушаал
- “Хот, тосгонд улаан шугам төсөллөх ба тогтоох заавар”
  ЗТБХБ-ын Сайдын 2011 оны 178 дугаар тушаал

## 155 дугаар дүрэм

1. Нийтлэг үндэслэл

2. Удирдлага, зохион байгуулалт

3. Ерөнхий архитекторын эрх, үүрэг /20 заалт/

4. Хүлээх хариуцлага

## Дүрмийн төсөл

1. Нийтлэг үндэслэл

2. Удирдлага, зохион байгуулалт

3. Ерөнхий архитекторын үйл ажиллагаа /15 заалт/

**4. Тайлан гаргах хэлбэр**

**5. Ерөнхий архитекторын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх**

6. Бусад

**Хавсралт-1. Ерөнхий архитекторын үйл ажиллагааны тайлан гаргах загвар**

**Хавсралт-2. Ерөнхий архитекторын үйл ажиллагаар үнэлэх**

**Хавсралт-3. Хот байгуулалтын архивын мэдээ ирүүлэх загвар**

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,**
**ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**


ХОЛБОО БАРИХ
Хаяг: Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 12-р байр
Утас: 976-51-263676
info@gazar.gov.mn